

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

/2019 оны эхний хагас жилийн байдлаар /

2019.06.26

Дархан-Уул

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий Сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Албан даалгавар, ЗГХЭГ-ын даргын тушаалын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 80 шийдвэрийн 137 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэгдэж ирсэн тайланг уншин танилцаж, боловсруулалт, сайжруулалтыг 1 удаа, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээллийг Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Цэргийн штабын тухайн асуудлыг хариуцсан албан тушаалтнуудаас тодруулга авах замаар цуглуулсан нэмэлт мэдээ, мэдээлэлд үндэслэн сайжруулалтыг гүйцэтгэв.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

2019 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 1 хуулийн 2 заалт,
- ✓ УИХ-ын 1 тогтоолын 1 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 2 тогтоолын 3 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2 зарлигийн 3 заалт,
- ✓ ҮАБЗ-ийн 2 зөвлөмжийн 2 заалт,
- ✓ Засгийн газрын 53 тогтоолын 71 заалт,
- ✓ Ерөнхий Сайдын 1 захирамжийн 5 заалт,

- ✓ Засгийн газрын хуралдааны 15 тэмдэглэлийн 22 заалт,
- ✓ Засгийн газрын 1 албан даалгаврын 12 заалт,
- ✓ ЗГХЭГ-ын 1 тушаалын 15 заалт, нийт 80 шийдвэрийн 137 заалтыг хяналтанд аван хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2018 оны мөн үетэй харьцуулахад 12 шийдвэрийн 32 заалтаар илүү байна.

### Гурав. Үнэлгээний дүгнэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2019 оны эхний хагас жилийн байдлаар **75.64** хувийн хэрэгжилттэй **3.75** онооны үнэлгээтэй байна.

### Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Биелэлт	Нийт	Үүнээс										
			МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал	
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	<b>80</b>	1	1	2	3	2	53	1	15	1	1	
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	<b>137</b>	2	1	3	4	2	71	5	22	12	15	
3.	Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	<b>54</b>	1	-	-	-	1	21	1	13	4	13
		Хэрэгжих шатанд 70%(50-89%)	<b>61</b>	1	-	2	2	1	36	4	7	6	2
		Хэрэгжилт хангалтгүй 30%(10-49%)	<b>13</b>	-	1	1	2	-	8	-	1	-	-
		Хэрэгжээгүй 0% (0-9%)	<b>5</b>	-	-	-	-	-	4	-	1	-	-
	Хугацаа болоогүй/ Үнэлэх боломжгүй	<b>4</b>	-	-	-	-	-	2	-	-	2	-	
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		<b>75.64% буюу 3.75 оноо</b>	85.0% буюу 4.25 оноо	30.0% буюу 1.50 оноо	56.66% буюу 2.83 оноо	50.0% буюу 2.5 оноо	85.0% буюу 4.25 оноо	70.43 оноо буюу 3.52 оноо	76.0% буюу 3.80 оноо	82.72% буюу 4.13 оноо	82.0% буюу 4.10 оноо	96.0% буюу 4.80 оноо	

2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад авсан шийдвэрийн төрлийг 2018 оны мөн үеийн хяналтад авсан шийдвэрийн төрөлтэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

Он	Заалтын тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2018 оны эхний хагас жил	105	2	3	3	6	3	50	5	20	13	-
<b>2019 оны эхний хагас жил</b>	<b>137</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>71</b>	<b>5</b>	<b>22</b>	<b>12</b>	<b>15</b>
<i>Зөрүү /их, бага/</i>	<i>+32</i>	<i>0</i>	<i>-2</i>	<i>0</i>	<i>-2</i>	<i>-1</i>	<i>+21</i>	<i>0</i>	<i>+2</i>	<i>-1</i>	<i>+15</i>

### Холбогдох зохицуулалтын салбараар нь харуулбал:

№	Биелэлт	Нийт	Зохицуулалтын салбар										
			Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Төлөвлөлт, санхүү хөрөнгө оршмалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлаг хамгаалах, гамшгаас урьд, сэргийлэх	Барилга хот байгуулалт	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	80	12	12	4	8	15	5	3	7	4	5	5
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	137	33	15	6	22	21	9	5	10	5	5	6
3.	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	54	11	6	4	17	7	3	1	2	1	2	1
	Хэрэгжих шатанд 70% (50-89%)	61	17	8	1	4	8	6	4	4	2	2	3
	Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	13	-	-	-	1	6	-	-	3	1	1	2
	Хэрэгжээгүй 0% (0-9%)	5	2	1	1	-	-	-	-	1	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй/ үнэлэх боломжгүй	4	3	-	-	-	-	-	-	-	1	-	-
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		<b>75.64% буюу 3.75 оноо</b>	76.33% буюу 3.81 оноо	77.30% буюу 3.86 оноо	78.33% буюу 3.91 оноо	91.36% буюу 4.56 оноо	68.57% буюу 3.42 оноо	80.0% буюу 4.0 оноо	76.0% буюу 3.8 оноо	57.0% буюу 2.85 оноо	67.5% буюу 3.37 оноо	74.0% буюу 3.7 оноо	61.66% буюу 3.08 оноо

2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналтад авсан шийдвэрийг зохицуулалтын салбарын заалтын тоо нь 2018 оны мөн үетэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

Он / заалтын тоо	Зохицуулалтын салбараар, үүнээс											
	Ерөнхий чиг үүргийн салбар	Байгаль орчин аялал жуулчлал	Төлөвлөлт, санхүү хөрөнгө оруулалт	Хууль эрх зүй	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэр	Батлаг хамгаалах, гамшгаас урьд, сэргийлэх	Барилга хот байгуулалт	Боловсрол соёл шинжлэх ухаан спорт	Зам тээвэр	Хөдөлмөр нийгмийн хамгаалал	Эрүүл мэнд	Уул уурхай
2018 оны эхний хагас жил	105	28	15	6	9	13	10	5	4	3	5	7
<b>2019 оны эхний хагас жил</b>	<b>137</b>	<b>33</b>	<b>15</b>	<b>6</b>	<b>22</b>	<b>21</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>10</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>6</b>
<i>Зөрүү / их, бага/</i>	<i>+32</i>	<i>+5</i>	<i>0</i>	<i>0</i>	<i>+13</i>	<i>+8</i>	<i>-1</i>	<i>0</i>	<i>+6</i>	<i>+2</i>	<i>0</i>	<i>-1</i>

### **Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/**

1. ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 2019.06.14-ны өдрийн Мэдээллийн цагаар хүргэсэн зөвлөмжийн хүрээнд цахим сангийн хяналтаас хасуулах санал өгсөн арга хэмжээг бодлогын хэлтсүүд дотоодын хяналтандаа авч, хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллах,
2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн Засаг даргын 2017. 2018 онуудад баталсан “Зөвлөмж” -үүдийг үйл ажиллагаандаа мөрдөх,
3. Нэгтгэл тайлан хугацаанаас 6 өдөр буюу 48 цагаар хоцорч (2018.06.25-ны өдрийн 22.45 цагт) ХШҮДАХ-т ирсэн боловч Засгийн газрын 1 тогтоолын 1 заалтыг орхигдуулсан байсныг залруулж ажиллалаа. Цаашид хэрэгжилтгүй, заалт байхад анхаарч ажиллах,
4. Зарим заалтын хэрэгжилтүүд хэтэрхий дэлгэрэнгүй, гол үр дүнг тайлагнаагүй байх тул цаашид 2000 тэмдэгтэд багтаан үр дүнг тайлагнахад анхаарах (2019 оны 03 дугаар хуралдааны тэмдэглэлийн 7, 8, 11 заалт; Засгийн газрын 2017 оны 98 тогтоолыг 3 заалт гэх мэт)-ыг тус тус зөвлөж байна.

### **Тав. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:**

2019 оны эхний хагас жилд нийт 33 шийдвэрийн 59 заалтыг хяналтаас хасуулах тухай саналыг тайлбарын хамт цахим санд тэмдэглэж, орууллаа. Энэ нь нийт заалтын 43.0%-ийг эзэлж байна.

Хяналтнаас хасах саналын тоог 2018 оны мөн үеийн саналын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хасах санал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
2018 оны эхний хагас жил	8	9 (8.6%)
<b>2019 оны эхний хагас жил</b>	<b>33</b>	<b>59 (43.0%)</b>
Зөрүү		

Дэлгэрэнгүйгээр үзүүлбэл:

Д/Д	ШИЙДВЭР	ЗААЛТ	ТАЙЛБАР
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 1. ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ</b>			
1.	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018-01-31 Дугаар 2018_32 тогтоол	4. ...иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийг нийтийн эрх ашиг, үндэсний язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллахыг уриалсугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж үр дүнг тайлагнасан тул хяналтаас хасах.
2.	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258 тогтоол	1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг 2018 онд тооцуулсан, ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулагдсан судалгааны

			багт тайлагнаж ажилласан тул хяналтнаас хасах
3.	2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр 16 дугаар тэмдэглэл 2018-04-04 Дугаар 2018_16	ХҮ.2 Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Бүрэн хэрэгжиж, тогтмолжсон тул хяналтнаас хасуулах
4.	2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2018-05-16 Дугаар 2018_21	XXIX.2. 3. Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, 1 удаагийн буюу цаг үеийн шинжтэй, жил бүр тэмдэглэлээр үүрэг чиглэл өгөгдөж тухайн жилдээ хэрэгжилтийг тооцуулдаг тул хяналтнаас хасах  2019.04.03-ны өдрийн 15 дугаар тэмдэглэл
		XXIX.2. 4. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр Албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав.	2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж үр дүнг тайлагнасан тул хяналтаас хасах.
5.	Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017-10-26 Дугаар 2017_01	1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, үр чадвартай ажиллах; 1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх; 1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахиж; 1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх. 2. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 2.1. Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг тухайн жилдээ тооцуулсан, цаг үеийн шинжтэй тул хяналтнаас хасуулах

		<p>2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан лиценз болон бусад тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулж ажиллах;</p> <p>2.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх;</p> <p>2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх;</p> <p>3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна.</p> <p>4. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна.</p>	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Цаг үеийн шинжтэй тул хяналтнаас хасуулах
<b>5 шийдвэрийн 15 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 2 БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b>			
6.	Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-02-06 Дугаар 2018_43	1.18 нийслэлээс орон нутагт шилжин суурьшиж мал аж ахуй, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжин ажлын байраар хангах, урамшуулах асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж <b>2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор</b> Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг... болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Цаг үеийн шинжтэй тул хяналтнаас хасуулах
7.	2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр 13 дугаар тэмдэглэл 2018-03-13 Дугаар 2018_13	1.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй <b>2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж</b> , төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлэх	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг тооцуулсан, хяналтнаас хасуулах
8.	2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл 2017-08-17 Дугаар 2017_36	ХҮҮ.3.2. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан <b>"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"</b> -ын хэрэгжилтийг бүрэн хангуулах, эвдэрсэн газрын тооллого хийх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
<b>3 шийдвэрийн 3 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 3. ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>			
9.	Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны	1.1- 1.8 Засгийн газраас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг тухайн ондоо тооцуулсан, 1 удаагийн

	Төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай 2017-12-13 Дугаар 2017_337	хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль санаачлахгүй байх зарчим баримталж байгаатай холбогдуулан батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, аливаа өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулах;	шинжтэй тул хяналтнаас хасуулах
		7.1-7.4 Орон нутгийн 2018 оны төсвийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 7.1. орон нутгийн төсвийн суурь зарлагад нэмж тусгагдсан хөрөнгийн зардал, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон орон нутагт үүссэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зориулалтын дагуу хууль тогтоомжид нийцүүлэн үр ашигтай зарцуулах;	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг хугацаанд тооцуулсан, 1 удаагийн шинжтэй буюу цаг үеийн шинжтэй тул хяналтнаас хасуулах
10.	Аргачлал шинэчлэн батлах тухай “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2018-01-24 Дугаар 2018_20	2. Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай. 4. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг тухайн ондоо тооцуулсан тайлан нь хүргэгдсэн тул хяналтнаас хасах
11.	2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 23 дугаар тэмдэглэл 2015-04-23 Дугаар 2015_23	2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлийг гаргуулан хянан баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Мэргэжлийн байгууллага тогтмол хянан баталгаажуулж ажиллаж, хэрэгжилт тогтмолжсон тул хяналтнаас хасуулах
<b>3 шийдвэрийн 5 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 4. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ</b>			
12.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016 №51	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай.	Засгийн Газар, АТГ-т даалгасан, аймгийн Засаг даргад үүрэг болгоогүй, заалт тул хяналтнаас хасуулах
13.	Журам батлах тухай 2017-04-12 Дугаар 2017_111	2 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн заавар, аргачлалаар хангаж ажиллахыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад, журмыг эрхлэх ажлынхаа хүрээнд үе шаттайгаар нэвтрүүлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. /“Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”/	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах

14.	Хөтөлбөр батлах тухай 2017-05-24 Дугаар 2017_148	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
15.	Ажлын хэсэг байгуулах тухай /Аймаг, сум, дүүрэгт хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан, авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдсон, хүнд суртал гаргасан, ажлын байран дээр архидан согтуурсан, хадгалсан албан тушаалтантай 2018-08-31 Дугаар 2018_255	1.1 , 1.2, 2.1, 2.3.1-2.3.14, 3.1 -хууль тогтоомжийн хэрэгжилтийг бодитой дүгнэх, зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулсан байдал; -ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, байгууллагын дотоод дүрэм, журамд тусган мөрдүүлж ажилласан байдал; - албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусгасан байдал; - согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон албан хаагчид хариуцлага тооцсон эсэх, сахилгын шийтгэлийг ажлаас халах хүртэл хүндрүүлэн оногдуулсан байдал... / 13 заалт/	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Хэрэгжилтийг тооцуулсан, үйл ажиллагаа хэвшсэн тул хяналтнаас хасуулах
16.	2015_346. Хөтөлбөр батлах тухай / 2015-08-24 / ЗГ-ын тогтоол “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг .....аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож...	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
17.	2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр 01 дүгээр тэмдэглэл 2015-01-07 Дугаар 2015_1	4.1. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл боловсруулахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийн саналыг авч, шаардлагатай бол саналыг тусгах арга хэмжээ авах;	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
<b>6 шийдвэрийн 18 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 5. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭР</b>			
18.	“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай 2018-01-10 Дугаар 2018_12	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. 3. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах



		хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, явц, үр дүнг жил бүрийн 5 дугаар сард багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	
19.	“Ноолуур” хөтөлбөр батлах тухай 2018-02-06 Дугаар 2018_47	3. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаадын зээл тусламжаар санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
20.	Хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2018-07-04 Дугаар 2018_218	Хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2018-07-04 Дугаар 2018_218 3. Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. 3.1-3.14	МУЗГ-ын 2018 оны 218 дугаар тогтоолын хэрэгжилт тухайн жилдээ хэрэгжин тайлан нь салбарын яаманд хүргэгдэн, хэрэгжилтийг тооцуулсан тул хяналтаас хасах
21.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-08-22 Дугаар 2018_267	6. Аймаг, сумын хүнс, хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн газар, тасгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, Бүрэн хэрэгжсэн тул хяналтнаас хасуулах
22.	2017 оны 8 дугаар сарын 9-ний өдөр 35 дүгээр тэмдэглэл 2017-08-09 Дугаар 2017_35	XX.1. 4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд ургац хураалт, мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгаль цаг уурын болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах, хадлан, ногоон тэжээл болон бусад тэжээл бэлтгэх, худалдан авч нөөц бүрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	ЗГ-ын 2017 оны 47 дугаар хурлын тэмдэглэлийн хэрэгжилт тухайн жилдээ хэрэгжин тайлан нь салбарын яаманд хүргэгдсэн тул хяналтаас хасах
23.	2017 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2017-11-08 Дугаар 2017_47	Ү1.2. 3. Мал аж ахуйн салбарын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: Малын гоц халдварт өвчний вакцин тарих явцад тавих хяналтыг сайжруулах, өвөлжилт, хаваржилтын үед хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор байнгын бэлэн байдалд ажиллахыг бүх шатны Засаг дарга, Мал эмнэлэг, үржлийн газрын дарга П.Ганхуяг нарт тус тус үүрэг болгов. Ү1.2.2 Мал аж ахуйн салбарын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангасан дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:Цас ихтэй байгаа бүс нутагт отроор яваа малчдад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Г.Сарангэрэл, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГ-ын 2017 оны 47 дугаар хурлын тэмдэглэлийн хэрэгжилт тухайн жилдээ хэрэгжин тайлан нь салбарын яаманд хүргэгдсэн тул хяналтаас хасах
<b>6 шийдвэрийн 8 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 6. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ</b>			
24.	Журам батлах тухай	2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Батлан	

	"Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам" 2018-03-27 Дугаар 2018_80	хамгаалахын сайд Н.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
25.	Журам батлах тухай 2017-05-17 Дугаар 2017_144	2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
26.	Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай 2018-08-15 Дугаар 2018_249	1. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболдод үүрэг болгосугай.	
27.	Гамшиг, галын аюулгүй байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-04-06 Дугаар 2018_68	орон сууц, олон нийтийн барилга байгууламж, хүн ам олноор цугларах үзвэр, үйлчилгээний газар, галт тэрэг, нисэх онгоцны буудал, эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийн гамшиг, гал түймрийн үед ашиглах орц, гарцын төлөвлөлт, техникийн шаардлага, гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах зориулалт бүхий техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт, бэлэн байдалд болон тэдгээр объектод гал унтраах машин нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийг хүргэхэд шаардлагатай орон зай, гудамж, замын сүлжээ хүрэлцэж байгаа эсэхэд <b>2018 оны 5 дугаар сарын 1-ний дотор хяналт шалгалт хийж</b>	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, хэрэгжилтийг тооцуулсан, цаг үеийн шинжтэй тул хяналтнаас асуулах
<b>4 шийдвэрийн 4 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 8. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТ</b>			
28.	<b>Үндэсний хөтөлбөр</b> батлах тухай 2018-08-08 Дугаар 2018_241	2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, орон нутгийн хэмжээнд дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
29.	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	
<b>2 шийдвэрийн 2 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 10. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ</b>			
30.	<b>Үндэсний хөтөлбөр</b> батлах тухай 2017-11-29 Дугаар 2017_321	3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг .... аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 "Дүгнэлт, зөвлөмжийн тухай" албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
<b>1 шийдвэрийн 1 заалт</b>			
<b>САЛБАР ЧИГЛЭЛ: 11. ЭРҮҮЛ МЭНД</b>			
31.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус	2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах	

	эргэлттэй тэмцэх <b>үндэсний хөтөлбөр</b> батлах тухай 2017-03-07 Дугаар 2017_77	хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
32.	<b>Үндэсний хөтөлбөр</b> батлах тухай 2017-03-07 Дугаар 2017_78	2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, холбогдох сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”	Засгийн газрын 2019 оны 15 дугаар тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 “Дүгнэлт, зөвлөмжийн тухай” албан бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор дотоодын хяналтандаа авч цахим сангийн хяналтнаас хасуулах
33.	<b>Үндэсний хөтөлбөр</b> батлах тухай 2017-04-12 Дугаар 2017_112	3.Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр, Сангийн сайд Б.Чойжилсүрэн болон Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	
			<b>3 шийдвэрийн 3 заалт</b>
<b>Нийт 33 шийдвэрийн 59 заалт</b>			

ТАНИЛЦСАН:  
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА С.НАСАНБАТ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН